



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/481

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Боловсролын хэлтсийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 14,533,694.40 (арван дөрвөн сая таван зуун гучин гурван мянга зургаан зуун ерэн дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Налайх дүүргийн Голомт сургууль, Эрдмийн оргил цогцолбор сургууль, 140 дүгээр цэцэрлэгт хавсралтын дагуу тус тус шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн Боловсролын хэлтэс (Б.Энх-Учрал)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг дээрхи байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 144 дугаар тушаалын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: Налайх дүүргийн боловсролын хэлтэс

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
Тоног, төхөөрөмж										
1	Суурин компьютер /Dell-7010/	2024.09.05	ш	1	2,550,000.00	2,550,000.00	127,500.00	2,422,500.00	Боловсролын хэлтэс	Голомт сургууль
2	Суурин компьютер /Dell-7010/	2024.09.05	ш	1	2,550,000.00	2,550,000.00	127,500.00	2,422,500.00	Боловсролын хэлтэс	Эрдмийн оргил цогцолбор сургууль
3	Суурин компьютер /Dell-7010/	2024.09.06	ш	1	2,550,000.00	2,550,000.00	127,500.00	2,422,500.00	Боловсролын хэлтэс	140 дүгээр цэцэрлэг
4	Электрон самбар	2018.06.30	ш	1	2,306,835.20	2,306,835.20	1,898,332.87	408,502.33	Боловсролын хэлтэс	140 дүгээр цэцэрлэг
5	Проектор NEC	2018.06.30	ш	1	3,497,064.00	3,497,064.00	2,877,792.25	619,271.75	Боловсролын хэлтэс	140 дүгээр цэцэрлэг
Машин тоног, төхөөрөмжийн дүн										
							13,453,899.20			
Тавилга, эд хогшил										
1	Самбарын хөл	2018.06.30	ш	1	1,079,795.20	1,079,795.20	888,581.73	191,213.47	Боловсролын хэлтэс	140 дүгээр цэцэрлэг
Тавилга, эд хогшлын дүн								191,213.47		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН							14,533,694.40			